



2020-21 ОНЫ АЖЛЫН ЯВЦ

Эрдэс бүтээгдэхүүн дэх дагалдах элементүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) тооцох олон улсын туршлага, журам, аргачлал. Эрдэс бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах метал, элементүүдэд АМНАТ ногдуулахтай холбоотой Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмууд, мөн эрдсийн салбарын болон АМНАТ-ийн тоон мэдээллүүдийг АМЭП 2 хөтөлбөрийн хүрээнд манай мэргэжилтнүүд болон гадаадын зөвлөхөөс бүрдсэн баг судалж, тайлан гаргалаа. Энэ судалгааны багийн бүрэлдэхүүнд ажилласан олон улсын зөвлөх Монгол Улсад ногдуулж буй дагалдах метал, элементүүдийн АМНАТ-ийг Австрали болон хэд хэдэн орны практиктай харьцуулан судалсан бөгөөд МУ-д хэрэгжүүлж буй АМНАТ ногдуулах журам, практик нь олон улсынхаас нэлээн онцгой болохыг тэмдэглэсэн байна. АМЭП 2 хөтөлбөрийн судлаачдын баг энэхүү харьцуулсан судалгааны дүнгээ яамдын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэгт танилцууллаа. Эрдэс бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах элементүүдэд АМНАТ ногдуулах талаар МУ-д мөрдөгдөж буй дүрэм журам, аргачлалыг олон улсын практиктай хэрхэн уялдуулах талаар зөвлөмж боловсруулж, мөн ажлын хэсэгт хүргүүлээд байна.

Байгаль орчны аудитор болон аудитын компаниудын чадавхыг нэмэгдүүлэх.

АМЭП 2 хөтөлбөрийн зөвлөхүүд Байгаль орчны аудитын холбоо (БОАХ)-той хамтран, байгаль орчны аудиторудыг гэрчилгээжүүлэх журам, чанарын баталгаажуулалт хийх үе шатуудыг боловсруулж, эцэслэн батлуулахаар ажиллаж байна. Байгаль орчны аудиторудыг бэлтгэдэг олон улсын сургалттай харьцуулахад Монгол улсын байгаль орчны аудиторудад зориулсан сургалтын агуулга харьцангуй сайн гарчээ. Цаашид сургалтын агуулгыг улам сайжруулахын тулд цогц чадамжид суурилж, үр чадвар ба хандлагыг сайжруулахад чиглэсэн менежментийн тогтолцоог түлхүү оруулж өгөх шаардлагатай байна. БОАХ-ны гишүүдийг сургагч багш болгон бэлтгэх сургалтууд 2021 оны 6 дугаар сард болно.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн зохицуулалт, шинэчлэлийг дэмжих техникийн түслалцаа.

Энэ чиглэлээр Монгол, Австралийн зөвлөхүүдээс бүрдсэн баг УУХҮЯ-ны төлөөлөлтэй уулзаж, тэдний зүгээс тайланд тусгах шаардлагатай асуудлыг дахин баталгаажуулж, урьдчилсан байдлаар судалгааны тайлангийн дүгнэлтүүдээ танилцууллаа. Тус тайланд өнгөрсөн туршлага, хууль эрх зүйн орчин, мөн хайгуулын тусгай зөвшөөрлийн асуудал МУ-ын Үндсэн хуульд хэрхэн тусгагдсан зэргийг судлан, улмаар бусад улстай харьцуулан дүгнэсэн. Баруун Австрали, Куинслэнд мужийн хайгуулын тусгай зөвшөөрлийг хэрхэн зохицуулдаг талаарх тайланг боловсруулж дуусгалаа. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход мэдээллийн технологийг хэрхэн ашигладаг талаар судалгааны ажил хийгдэж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) хийхэд иргэдийн оролцоог сайжруулах нь.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаа талаарх үнэлгээг хийхдээ БОНБУ-ний тайлангуудыг судалж, мөн оролцогч талуудаас судалгаа авч байна. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах талаар олон улсын туршлагын тайланд тодорхой орнуудыг сонгон, тайлангийн анхны хувилбарыг боловсруулж дууслаа.

2019 онд АМЭП 2 хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хоёр дох санхүүгийн жилийн тайлангаа гаргах гэж буйдаа баяртай байна. Дэлхий дахиныг нэрвэсэн цар тахлаас үүдэн, хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарим нэг өөрчлөлт орсон хэдий ч бид мөн цаг үеэ даган хувьсан өөрчлөгдөж чадлаа.

Хүнд хэцүү цаг үед ч ажлаа урагшлуулж, зорилтдоо хүрч чаддаг баг, хамт олныг удирдан ажиллаж буйдаа би туйлын баяртай байна. Мөн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн салбарт хамтран ажилладаг түншүүдийнхээ ачаар АМЭП 2 хөтөлбөр энэ онд хэрэгжүүлж буй зургаан төсөлдөө томоохон ахиц гаргаж чадлаа.

Энэхүү мэдээллийн хуудсаар дамжуулан, АМЭП 2 хөтөлбөрийн гол амжилтуудыг та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна. Дагалдах элементүүдэд ногдуулах татварын харьцуулсан судалгаа хийж дуусгалаа. Долоон төрлийн ашигт малтмал эрж хайх, нөөцийг нь тайлагнах журам боловсрууллаа. Хөнгөн цагаан, литий-цезий, газрын ховор элемент, бал чулуу, давс, карбонат чулуулаг, элс хайрга эрж хайх, тайлагнах аргачилсан зөвлөмжтэй мэргэжлийн байгууллагууд танилцаж байна. АМЭП Мэдээллийн товхимлын долоо дахь дугаараас та бүхэн манай үйл ажиллагаа, хөтөлбөрийн явцын талаар дэлгэрүүлэн уншаарай. Мөн amep.mn манай цахим хуудсаар зочлохыг урьж байна. Эрүүл энхийг хүсье.

Хөтөлбөрийн удирдагч
Кирстен Ливермор



Асуулт
байна уу?

Та АМЭП хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл www.amep.mn цахим хуудсаар зочилж, эсвэл Хамтын ажиллагааны Менежер П.Оюунбилэгтэй oyunbileg@amep.mn хаягаар холбогдоорой.

2020-21 оны ажлын явц (Үргэлж.)

Эдгээр тайлан, судалгааны үр дүнг оролцогч талуудад танилцуулж, улмаар оролцогч талуудтай хамтран дүрэм журамд өөрчлөлт оруулах зөвлөмж боловсруулна. Төслийн хүрээнд БОНБУ-ний үйл явцтай холбоотой олон нийтийн саналыг eic.mn цахим хуудсанд байрлуулахад нь БОАЖЯ-нд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж. Долоон төрлийн ашигт малтмал, тодруулбал хөнгөн цагаан, литий-цезий, газрын ховор элемент, бал чулуу, давс, карбонат чулуулаг, элс хайрга эрж хайх, тайлагнах журам боловсруулж дуусгалаа. Салбарын мэргэжилтэн, геологичид журамтай танилцан, саналаа өгч, редакцийн хяналт хийж байна. Зургадугаар сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

“Зохистой татварын хэмжээ” судалгаа. Энэ судалгаа нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон уул уурхайгаас орж ирэх орлогыг нэмэгдүүлэх замаар зэс, алтанд ногдуулах татварын оновчтой хэмжээг тогтоох зорилготой. “Зохистой татварын хэмжээ” судалгааг оролцогч тал, мэргэжилтнүүдэд зургадугаар сард танилцуулахаар төлөвлөж байна.

Хөрөнгө оруулалтын сан байгуулах талаарх судалгаа. Монгол, олон улсын эрдэмтдийн баг уул уурхайн салбараас орж ирэх орлогоос хөрөнгө оруулалтын сан байгуулах хуулийн төслийг судалж байна. Энэ судалгааны ажлын хүрээнд бусад улс орны Хөрөнгө оруулалтын сан, Баялгийн сан, тус сангуудаас дотооддоо хийсэн хөрөнгө оруулалт, тэдгээрээс авсан сургамж, сан руу орлого хийх, зарлага гаргах, хөрөнгө оруулалт, засаглалын бүтэц зэргийг тодорхойлно.



МАНАЙ ЗОРИЛТ:

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах.